



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэлмэн сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/31/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч: Г.Заяа
Утас: 92038288
Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Аудитор: Ц.Алтантуул
Утас: 91195554
Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022. 02. 21 № 1302/81

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэлмэн сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэлмэн сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022960

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал, материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52.02	63.24
33	АВЛАГА	0.1990	0.0049
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1990	0.0002
335	Бусад авлага	-	0.0047
3351	Байгууллагаас авах авлага	-	0.0047
35	БАРАА МАТЕРИАЛ	51.83	63.23
354	Хангамжийн материал	31.41	46.31
35410	Бичиг хэргийн материал	2.41	2.36
35420	Аж ахуйн материал	3.71	3.85
35430	Сэлбэг хэрэгсэл	1.04	1.04
35450	Барилгын засварын материал	0.49	0.54
35470	Бусад хангамжийн материал	23.75	38.52
35600	Мал амьтад	20.42	16.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	507.46	518.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	507.46	518.38
392	Биет хөрөнгө	490.13	501.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	764.76	810.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(354.34)	(410.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195.02	226.72
39204	Хуримтлагдсан элэгдэл	(147.16)	(161.38)
39205	Машин тоног төхөөрөмж	64.83	79.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44.39)	(51.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26.62	25.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21.45)	(22.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12.16	12.16
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5.92)	(7.09)
393	Биет бус хөрөнгө	17.32	16.84
39301	Програм хангамж	2.78	2.78
39302	Хуримтлагдсан элэгдэл	(0.52)	(1.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15.06	15.06
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	559.48	581.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.15	2.48
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.15	2.48
413	Өглөг	0.15	2.48
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.01	2.17
4136	Бусад өглөг	0.14	0.31
41361	Байгууллагад төлөх өглөг	0.14	0.31

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	559.33	579.13
51	Засгийн газрын хувь оролцоо	559.33	579.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	376.58	376.58
51101	Өмч: - төрийн	376.58	376.58
512	Хуримтлагдсан үр дүн	18.37	(2.20)
51210	Өмнөх үеийн үр дүн	18.37	18.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(20.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164.39	204.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	559.48	581.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	366.77	389.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366.77	389.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49.87	46.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49.87	46.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	316.91	343.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	316.91	343.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	417.46	458.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417.46	458.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401.25	414.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227.12	232.73
210101	Үндсэн цалин	209.54	213.22
210105	Гэрээт ажлын хөлс	17.58	19.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28.60	30.44
210201	Тэтгэврийн даатгал	19.70	21.53
210202	Тэтгэмжийн даатгал	2.32	2.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.84	1.85
210204	Ажилгүйдлийн даатгал	0.43	0.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4.31	4.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13.62	16.07
210301	Гэрэл, цахилгаан	1.09	1.15
210302	Түлш, халаалт	12.53	14.93
2104	Хангамж, бараа материалын зардал	21.87	26.34
210401	Бичиг хэрэг	2.98	3.20
210402	Тээвэр, шатахуун	12.99	15.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3.39	3.58
210408	Бараа материал акталсны зардал	2.52	4.12

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4.71	8.45
210604	Урсгал засвар	4.71	8.45
2107	Томилолт, зочны зардал	3.97	2.26
210702	Дотоод албан томилолт	3.97	2.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7.40	2.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6.06	1.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.23	0.54
210803	Даатгалын үйлчилгээ	0.47	0.47
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.18	0.13
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.04	0.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.26	0.18
210807	Газрын төлбөр	0.14	0.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93.97	95.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13.31	14.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.17	0.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80.49	80.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16.20	43.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	0.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	0.20
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16.20	43.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16.20	43.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41.02	(20.44)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.91	0.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.91	0.13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.91)	(0.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	40.11	(20.57)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376.58	164.39	(21.75)	519.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	376.58	164.39	(21.75)	519.21
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	40.37	40.37
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376.58	164.39	18.62	559.58
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	376.58	164.39	18.62	559.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	376.58	164.39	18.37	559.33

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	40.37	-	40.37
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(20.57)	(20.57)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376.58	204.76	(2.20)	579.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	366.77	389.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366.77	389.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49.87	46.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49.87	46.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	316.91	343.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	316.91	343.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	324.34	378.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324.34	378.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308.14	334.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227.12	232.73
210101	Үндсэн цалин	209.54	213.22
210105	Гэрээт ажлын хөлс	17.58	19.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28.65	30.24
210201	Тэтгэврийн даатгал	19.70	21.33
210202	Тэтгэмжийн даатгал	2.32	2.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.84	1.85
210204	Ажилгүйдлийн даатгал	0.43	0.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4.36	4.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7.25	16.07
210301	Гэрэл, цахилгаан	1.09	1.15
210302	Түлш, халаалт	6.16	14.93
2104	Хангамж, бараа материалын зардал	19.67	22.36
210401	Бичиг хэрэг	3.30	3.34
210402	Тээвэр, шатахуун	12.99	15.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3.39	3.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5.32	8.94
210604	Урсгал засвар	5.32	8.94
2107	Томилолт, зочны зардал	3.97	2.26
210702	Дотоод албан томилолт	3.97	2.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7.49	9.44

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6.06	8.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.23	0.23
210803	Даатгалын үйлчилгээ	0.47	0.47
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.18	0.13
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.04	0.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.35	0.18
210807	Газрын төлбөр	0.14	0.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8.68	12.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8.21	12.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.46	0.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16.20	43.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	0.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	0.20
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16.20	43.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16.20	43.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42.43	11.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42.43	11.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42.43	11.50
2200	Дотоод эх үүсвэрээр	42.43	11.50
222001	Тоног төхөөрөмж	-	11.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(42.43)	(11.50)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304.56	341.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304.56	330.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304.56	330.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232.61	232.73
210101	Үндсэн цалин	212.98	213.22
210105	Гэрээт ажлын хөлс	19.63	19.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31.40	30.24
210201	Тэтгэврийн даатгал	22.10	21.33
210202	Тэтгэмжийн даатгал	2.33	2.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1.86	1.85
210204	Ажилгүйдлийн даатгал	0.47	0.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4.65	4.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10.19	16.07

210301	Гэрэл, цахилгаан	2.79	1.15
210302	Түлш, халаалт	7.40	14.93
2104	Хангамж, бараа материалын зардал	19.67	22.36
210401	Бичиг хэрэг	3.30	3.34
210402	Тээвэр, шатахуун	12.47	15.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3.90	3.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.50	8.94
210604	Урсгал засвар	1.50	8.94
2107	Томилолт, зочны зардал	4.83	2.26
210702	Дотоод албан томилолт	4.83	2.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.56	8.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.20	7.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.23	0.23
210803	Даатгалын үйлчилгээ	0.47	0.47
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.23	0.13
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.07	0.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.20	0.18
210807	Газрын төлбөр	0.14	0.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1.80	9.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1.50	9.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.30	0.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	11.50
2200	Дотоод эх үүсвэрээр	-	11.50
222001	Тоног төхөөрөмж	-	11.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	343.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	343.50
132001	Орон нутгийн төсвөөс	-	343.50

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4.56
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	0.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	0.20

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	0.20
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	46.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	46.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагадаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	46.28

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэлмэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тэлмэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 3/18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэлмэн сумын Засаг даргын тамгын газар нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн орон нутгийн онцлог нөөц чадавхийг бүрэн дайчсан судалгаанд суурилсан эдийн засаг нийгмийн бодлогыг хэрэгжүүлж хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг хүн амд ил тод шуурхай хүртээмжтэй хүргэж улс аймгийн хэмжээнд тэргүүлэх түвшинд хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэлмэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 414.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	199.04	4.89	194.15
Бараа материал	51,825.74	63,232.94	(11,407.20)
Үндсэн хөрөнгө	507,455.44	518,376.04	(10,920.60)
Нийт хөрөнгийн дүн	559,480.22	581,613.87	(22,133.65)
Өглөг	149.84	2,479.60	(2,329.76)
Засгийн газрын хувь оролцоо	559,330.38	579,134.27	(19,803.89)
Өр төлбөр эдийн өмчийн дүн	559,480.22	581,613.87	(22,133.65)

Авлагын данс 194.1 мянган төгрөгөөр буурсан нь авлагаа барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 11,407.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалыг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,920.6 мянган төгрөгөөр өссөн нь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны 2,329.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн үнэлгээний хөлс төлөөгүйтэй холбоотой үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19,803.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 343,503.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 343,503.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 343,503.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 341,895.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,608.3 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 46,279.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлэн байгууллагын үйл ажиллагаанд 4,758.4 мянган төгрөгийг зарцуулж 41,520.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Эд хариуцагч, жолооч нартай тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудас хөтөлж хяналт тавиагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн хязгаарлалттай дүгнэлт авсан бөгөөд 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын төсвийн зарцуулалтанд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 42.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Барилгын дахин үнэлгээ 40.4 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй
- Өглөгийн дүнг 2.2 сая төгрөгөөр дутуу тусгасан алдааг тус тус залрууллаа.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага өгөөгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловрсуулан мөрдөөгүй, 2.5 сая төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй, шатахууны тооцоог бодохдоо шатахуун зарцуулалтын нормыг мөрдөөгүй;
- ✓ Хөрөнгийн тооллого хийж гүйцэтгэсэн боловч тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс 1.9 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан, эд хариуцагчтай үндсэн хөрөнгө болон бараа материалын тооцоог бодоогүй;

- ✓ Аймгийн Иргэдийн Хурлаас баталсан хөрөнгө актлах шийдвэрийн дүнгээс данснаас хассан бараа материалын дүн 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөх;
- ✓ Зам тээврийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2-р хавсралтыг мөрдөн ажиллах, автомашины үйлдвэрлэсэн огнооноос шалтгаалан тухайн автомашинд тохирох нормыг зааврын дагуу тогтоон мөрдөх, жолоочийн тооцоонд тавих хяналтыг сайжруулах;
- ✓ Хөрөнгийн тооллогын комиссын ажлыг нягтлах, эд хариуцагчтай хөрөнгийн тооцоог бодож хэвших;
- ✓ Хөрөнгө актлахдаа өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гаргуулан, аймгийн ИТХ-д саналаа хүргүүлж байх, хөрөнгө актлах саналыг явуулахдаа хөрөнгийн нэр төрөл, дүнг тулган шалгах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.	Тэлмэн сумын Засаг даргын тамгын газар	5	47.5	2	42.6					3	4.9
	Дүн	5	47.5	2	42.6					3	4.9

